



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/119

Батноров сум


Үр дүнгийн урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчийн мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.1, 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батноров сумын Засаг даргын Тамгын газрын дарга Алтанхуяг овогтой Борчулууныг 2025 оны 2 дугаар улирлын ажлын гүйцэтгэлийг 98.3 оноотой үнэлсэн тул үр дүнгийн урамшууллыг 07 дугаар сарын цалин дээр үндсэн цалингийн 50%-р бодож олгосугай.

2. Батлагдсан үр дүнгийн урамшууллыг холбогдох хууль журмын дагуу тооцож олгохыг Санхүү албаны нягтлан бодогч (Б.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ОТГОНБАЯР

232530028